



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 29 өдөр

Дугаар АТ96

Улаанбаатар хот

Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах
иргэдийг элсүүлэх, албанаас халах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Цэргийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 80, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/535 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цэргийн албыг биеэр дүйцүүлэх албанд 2024-2026 онд алба хаахаар хүсэлт гаргасан иргэдтэй гэрээ байгуулж, алба хаах хугацаанд, үүрэг гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Цэргийн штаб (дэд хурандаа Ш.Бат-Өлзий)-т үүрэг болгосугай.

2.Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийн нэрийн жагсаалтыг нэгдүгээр, 2022-2024 онд Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж, хугацаа дууссан иргэдийг халах, Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах журам зөрчсөн иргэдтэй гэрээг цуцлах нэрийн жагсаалтыг хоёрдугаар, Цэргийн дүйцүүлэх албанд элссэн иргэдийн үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай хувцас, тусгай хэрэглэлийн зардлыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн хувцас тусгай хэрэглэлийн зардалд шаардагдах 5,621,600 (таван сая зургаан зуун хориг нэгэн мянга зургаан зуун) төгрөгийг дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй

4. Үйл ажиллагааг зохион байгуулж дууссанаас хойш 5 хоногийн дотор танилцуулж, зарцуулсан санхүүгийн тайланг ирүүлэхийг Цэргийн штаб (дэд хурандаа Ш.Бат-Өлзий)-т, захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 8 дугаар сарын 08 өдрийн
А.1.1.6 захирамжийн гуравдугаар хавсралт

ЦЭРГИЙН ДҮЙЦҮҮЛЭХ АЛБАНД ЭЛССЭН ИРГЭДИЙН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХЭД ШААРДЛАГАТАЙ ХУВЦАС,
ТУСГАЙ ХЭРЭГЛЭЛИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Хувцас хэрэглэл	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Нэгж үнэ	Нийт /төгрөг/
1	Малгай (зуны саравчтай)	Ширхэг	4	25,000	100,000
2	Малгай (өвлийн ноосон)	Ширхэг	4	30,000	120,000
3	Китель, өмд (зуны)	Ширхэг	4	180,000	720,000
4	Хүрэм өмд (өвлийн)	Ширхэг	4	250,000	1,000,000
5	Гутал (зуны)	Ширхэг	4	170,000	680,000
6	Гутал (өвлийн)	Ширхэг	4	210,000	840,000
7	Ороолт (өвлийн)	Ширхэг	4	20,000	80,000
8	Цэрэг бүс /суран/	Ширхэг	4	70,000	280,000
9	Футболк	Ширхэг	4	30,000	120,000
10	Шорт	Ширхэг	4	35,000	140,000
11	Бэлтгэлийн хувцас	Ширхэг	4	150,000	600,000
12	Дүүргийн таних тэмдэг	Ширхэг	8	9,000	72,000
13	Цэргийн штабын лого	Ширхэг	8	9,000	72,000
14	Нэр	Ширхэг	8	6,600	52,800
15	Дүйцүүлэх алба хаагчийн тэмдэг	Ширхэг	8	6,600	52,800
16	Үнэмлэх	Ширхэг	4	5,000	20,000
17	Хөдөлмөр хамгааллын каск	Ширхэг	4	25,000	100,000
18	Тусгай зориулалтын бээлий	Ширхэг	4	18,000	72,000
19	Ноосон цамц	Ширхэг	4	125,000	500,000
НИИТ					5,621,600